

Хэрэглэгчдэд зориулсан Доктор МЭИК (Dr MEIC) сэтгүүлийн тусгай дугаар 2018 он №8

МОНГОЛ ЭМ ИМПЭКС КОНЦЕРН

SINCE 1923



АМЬДРАЛЫГ ТЭТГЭСЭН 95 ЖИЛ

ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Монгол Эм Импэкс Концерн үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн чанартай эм, эрүүл мэндийн бүтээгдэхүүнийг ард иргэддээ болон эмнэлэг эрүүл мэндийн байгууллагуудад хурдан шуурхай хүргэсээр ирсэн. Өнөөдөр ч энэ үүргээ амжилттай биелүүлж, залгамж чанараа хадгалан үйл ажиллагаа, үйлчилгээгээ улам өргөжүүлэн чанаржуулж ажиллаж байна. Анх 14 хүний орон тоотойгоор үйл ажиллагаагаа эхэлж байсан Монгол Эм Импэкс Концерн өдгөө Улаанбаатар хот болон 21 аймгийн аймгийг бүхэлд нь хамарсан үйл ажиллагааны өргөн цар хүрээ бүхий, 300 гаруй нарийн мэргэжлийн боловсон хүчин, ажилтан ажиллагсадтайгаар үйл ажиллагаагаа амжилттай явуулж өнөөдөр 95 жилтэйгээ учран золгож байна.

Монгол Эм Импэкс Концерн энэ олон жилийн туршлага, чадварлаг хамт олны хүчээр нийгэм болоод эрүүл мэндийн салбарт тулгамдаад буй асуудлыг соргоогоор мэдэрч түүнд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн дан ганц өөрийн үйл ажиллагаагаар бус бусад улсын болон хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлж нэгдсэн цогц менежментийн дагуу аливаа өвчлөлтэй тэмцэх үндсэн бодлогыг баримтлан ажиллаж байна.

Монгол Эм Импэкс Концерны эм, эмийн бүтээгдэхүүн нь урт удаан хугацааны судалгаа, шинжилгээ, зардал, өндөр хариуцлага, чадварлаг баг, хамт олны уйгагүй хөдөлмөрийн үр дүнд Монголд нэвтэрч өвчтөнд хүрдэг гэдгийг дурдах нь зүйтэй болов уу. Мөн бид өвчтөний эрүүл мэнд, эмчилгээний үр дүнг нэн тэргүүнд үзэж үйл ажиллагаагаа явуулдаг юм.

Өнгөрсөн хугацаанд бид дутуу нярайн эндэгдэл, элэгний өвчлөл, чихрийн шижин зэрэг эрүүл мэндийн салбарт тулгамдаад байгаа өвчлөлүүдийг бууруулахад чиглэсэн, түүний орчин үеийн эмчилгээний чиг хандлагыг Монголын эмчилгээний практикт нэвтрүүлэх, мөн тусламж дэмжлэг хэрэгтэй байгаа хэсэгт шаардлагатай эм бэлдмэлийг хандивлах зэрэг олон ажлуудыг хэрэгжүүлэн ажиллалаа. Хамгийн гол нь бидний хийж буй энэ бүх ажил дан ганц Улаанбаатар хотоор хязгаарлагдалгүй орон нутгийн 21 аймагт байрлах салбар нэгжүүдээр дамжуулан Монгол орны өнцөг



булан бүрт хүрч олон гэр бүлд аз жаргал, элэг бүтэн амьдралыг бэлэглэсэн гэдгээр Монгол Эм Импэкс Концерны өнөр хамт олон бахархаж, урамшиж явдаг юм.

Ингээд Монгол Эм Импэкс Концерн хэмээх байгууллагад ажиллаж хөдөлмөрлөж буй нийт хамт олондоо, үеийн үеийн ахмад ажилтнууддаа болон бидэнтэй хамтран ажилладаг эмч мэргэжилтэн, бүх албан байгууллагуудад Монгол Эм Импэкс Концерн үүсгэн байгуулагдсан түүхт 95 жилийн ойн халуун баярын мэндийг хүргэн, эрүүл энх сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Хүндэтгэсэн,

**Монгол Эм Импэкс Концерны
гүйцэтгэх захирал, Ph.D
Б. БОЛОРМАА**

ОТРИЗОЛ-DF



Хүүхэд болон насанд хүрэгсдэд зориулсан хамрын цацлага, дусаалга

- Хамрын салст бүрхүүлийн үрэвслийн шинжтэй (хамрын ханиад) амьсгалын замын хурц эмгэгүүд
- Судас хөдөлгөөний шалтгаантай (вазомотор) хамрын салст бүрхүүлийн үрэвсэл
- Харшлын гаралтай хамрын салст бүрхүүлийн хурц үрэвсэл (ургамлын тоосонцорын харшил)
- Хамрын дайвар хөндийн үрэвсэл (синусит)
- Дунд чихний үрэвсэл (хавсарсан эмчилгээнд – хамар залгиурын салстын хөөнгийг багасгах зорилгоор)
- Хамарт оношлогооны ажилбарт бэлтгэх зорилгоор хэрэглэнэ

НИОТИТ-DF



Гадна болон дунд чихний идээт бус үрэвслийн эсрэг дусаалга

Ниотит-DF®-ийг хэрэглэхийн өмнө шилэн дусаагуур ба резинэн хөхөвчийг холбодог эргэдэг хуванцар тагаар флаконы тагийг солино. Мөн чихний гадна сувгийг цэвэрлэнэ. Өвчтөний толгойг эсрэг тал руу хазайлгаж чихний сувгийн арын дээд хананд бэлдмэлийг дусаана. Дусаасны дараа чихний цэцгийг хөвөнгөөр дарж иллэг хийнэ. Бэлдмэлийг чихэнд 10-15 минут байлгасны дараа толгойг эсрэг тал руу хазайлган бэлдмэлийг гаргана. Чихний гадна сувгийг хатааж ариун хөвөнгөөр бөглөнө. Дусал нь бүлээн, биеийн хэмтэй ижил дулаантай байх ёстой.

АЛЕРГОЗОЛ-DF



Нүд ба хамрын дусаалга

- Нүдний салст бүрхүүлийн улирлын чанартай харшлын гаралтай үрэвсэл сэдрэх
- Нүдний салст бүрхүүлийн жилийн туршид явагдах харшлын гаралтай үрэвсэл сэдрэх
- Контакт линз зүүсний улмаас нүдний салст бүрхүүл цочрох
- Гадны нөлөөний (үүнд, нарны гэрэл, тамхины утаа, усан сангийн ус) улмаас нүдний салст бүрхүүл цочрох
- Хамрын салст бүрхүүлийн цочмог үрэвсэл
- Хамар болон хамрын дайвар хөндийн салст бүрхүүлийн харшлын гаралтай үрэвсэл
- Хамрын салст бүрхүүлийн судас хөдөлгөөний шалтгаантай харшлын гаралтай үрэвсэл

АЛЕРГОЗОЛ-DF

2-с дээш насны хүүхэд болон насанд хүрэгчдэд зориулсан хамрын цацлага



- Нүдний салст бүрхүүлийн улирлын чанартай харшлын гаралтай үрэвсэл сэдрэх
- Нүдний салст бүрхүүлийн жилийн туршид явагдах харшлын гаралтай үрэвсэл сэдрэх
- Контакт линз зүүсний улмаас нүдний салст бүрхүүл цочрох
- Гадны нөлөөний (үүнд, нарны гэрэл, тамхины утаа, усан сангийн ус) улмаас нүдний салст бүрхүүл цочрох
- Хамрын салст бүрхүүлийн цочмог үрэвсэл
- Хамар болон хамрын дайвар хөндийн салст бүрхүүлийн харшлын гаралтай үрэвсэл
- Хамрын салст бүрхүүлийн судас хөдөлгөөний шалтгаантай харшлын гаралтай үрэвсэл

АМЬДРАЛЫГ ТЭТГЭСЭН 95 ЖИЛ

МОНГОЛЫН ЭМ ХАНГАМЖИЙН САЛБАРЫН УУГАН БАЙГУУЛЛАГА
МОНГОЛ ЭМ ИМПЭКС КОНЦЕРНЫ ТҮҮХ



МОНГОЛ ЭМ ИМПЭКС КОНЦЕРНЫ
ТҮҮХ БОЛ МОНГОЛЫН ЭРҮҮЛ МЭНД,
ЭМ ХАНГАМЖИЙН САЛБАРЫН ТҮҮХ ЮМ

МОНГОЛЫН ЭМ ХАНГАМЖИЙН САЛБАР БУЮУ МОНГОЛ ЭМ ИМПЭКС КОНЦЕРНЫ ТҮҮХ

Монгол Эм Импэкс Концерн нь 1923 онд “Нэгдүгээр эмийн сан” нэртэйгээр тулгын чулуугаа тавьж, үйл ажиллагаагаа эхэлжээ. Тэр цагаас хойш Монгол Эм Импекс Концерн нь Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулдаг бүх эмнэлэгүүд, эрүүл мэндийн байгууллага, хүн ардад зайлшгүй шаардлагатай чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангах нэр төртэй үүргээ 95 жилийн турш тасралтгүй, нэн хариуцлагатайгаар гүйцэтгэж ирсэн үндэсний хэмжээний ууган эм хангамжийн байгууллага болсон байна.

Монгол Эм Импэкс Концерны түүх нь Монголын эм хангамжийн салбарын түүхтэй шууд холбоотой юм. Энэ ч утгаараа Монгол улсын эм хангамжийн түүхийн нэрийн хуудас болсон тус компаний түүхийг 5-н үе шат болгон авч үзэж болох юм.

I ҮЕ ШАТ: Европын эм худалдах эмийн сан нээж, улмаар улсын эмийн сангуудыг байгуулж эхлэх /1923-1947/

II ҮЕ ШАТ: Улсын эмийн сангуудыг таван жилийн төлөвлөгөөтэйгээр хөдөө орон нутгийг хамруулан түлхүү хөгжүүлэх /1947-1960 он/

III ҮЕ ШАТ: Улсын эм хангамжийн үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлж, улсын эм хангамжийн тогтсон сүлжээтэй болох /1961-1990 он/

IV ҮЕ ШАТ: Зах зээлийн шилжилтийн үеийн эм хангамжийн тогтолцоог боловсронгуй болгон хөгжүүлэх/1990-2007/

V ҮЕ ШАТ: Монгол Эм Импэкс Концерны түүхийн шинэ хуудас /2007 он ба түүнээс хойш/



НЭГДҮГЭЭР ҮЕ ШАТ

Анхны эмийн сан нь тухайн үедээ 14 ажилтны орон тоотойгоор 7995 хятад янчааны үл хөдлөх хөрөнгөтэй, 1000 хятад янчааны гүйлгээ хөрөнгөтэйгээр, эрхлэгчээр нь тухайн үеийн ЗХУ-ын мэргэжилтэн А.И.Ржановский ажиллаж байсан байна.

Анхны эмийн сан нээгдсэний дараахан нь хувийн эмийн сангуудад эмийг бэлтгэх, хортой эмийг худалдах явдлыг хориглох тухай 1923 оны 11 дүгээр сарын 10-нд Ардын засгийн газрын тогтоол гарган эмийн зүйлд улсын онц эрх тогтоожээ.

1923 онд Ардын засгийн газрын шийдвэрээр 38,0 мянган төгрөг Москвад шилжүүлж эм барааны анхны гадаад захиалгаар импорт хийгдэж байжээ.

1926 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр УИХ-ын II тогтоолоор Цэргийн яамны анхны эмийн санг Дотоод явдлын яаманд шилжүүлэн Улсын эмийн сан гэж нэрлэх болжээ.

1928 оны 7 дугаар Алтанбулаг хотод хөдөөгийн анхны эмийн санг 25,000 төгрөгний төсөвтэйгээр байгуулжээ.

1930 онд ЭХЯ байгуулагдсаны дараахан БНМАУ-ын Эмийн сангийн төв склад байгуулагджээ.

1930 онд Улсын ҮI их хурлын шийдвэрээр төвд эмнэлгийн арга хэмжээний зардлыг улсын төсвөөс бүр мөсөн хасаж 1937 онд төвд эмийн худалдааны газрыг албан ёсоор хаажээ.

1931-1932 онд Баянтүмэн, Цэцэрлэг, Ховд аймгуудад эмийн сангууд нээгджээ.

1931 онд Улаанбаатар жороор бэлтгэсэн эмийн тоо 82272-т, гар худалдаагаар худалдсан эмийн тоо 82204-д тус тус хүрч 341 нэр төрлийн эм худалдаж байжээ.

1936-1937 онуудад Хөвсгөл, Завхан аймгуудад эмийн сан байгуулагдаж байжээ.

1935 онд нэг эмийн санд ногдох хүний тоо 147600 байсан бол, 1940 онд 44000 хүртэл буурч байжээ.

1945 он гэхэд нэг эмийн санд 24500 хүн ногдох болж нэг иргэн 6,4 төгрөгний эм бараа худалдан авдаг болсон байв.

1945-1947 онуудад сумдад эмийн сангийн салбарууд байгуулагдаж эмийн сангийн зохион байгуулалтад райончилсан систем бий болов.

1945 онд сумдын эмийн сан бүх эмийн сангийн 19,5%-ийг эзэлж байсан бол 1947 оны сүүлчээр 35,7%-ийг сумдын эмийн сангууд эзлэх болжээ.



ХОЁРДУГААР ҮЕ ШАТ

Эмийн сангийн ажлыг УАА соёлыг хөгжүүлэх төлөвлөгөөний дагуу тав, таван жилээр хөгжүүлэх ойрын болон хэтийн төлөвийг мөрдөж эхэлсэн байна.

Улсын хэмжээнд эмийн сангийн тоо 47,6%-иар нэмэгдсэн байна

Үүнээс хөдөө орон нутгийн эмийн сан 50%-иар нэмэгджээ. Мөн нэг эмийн санд ногдох хүн амын тоо 24,2%-иар өсчээ.



Анхны тусламжийн хайрцаг

Хөдөө орон нутагт олон тооны эмийн сангууд байгуулагдаж хүн амыг эрүүлжүүлэх ажил эрчимжсэнээр эмийн сангуудын эм барааны эргэлт 2,3 нэмэгдэж байжээ.

1960 оны улсын нийт, эмийн сангуудын 77,5%-ийг сумдын эмийн сангууд эзлэх болсон нь, хөдөөгийн хүн амд эмийн тусламжийг ойртуулах үйл ажиллагаа үлэмж амжилт олсныг харуулж байна. Энэ бүх хугацаанд улсын хэмжээнд эм зүйчдийн тоо 2,8 дахин өслөө.

ГУРАВДУГААР ҮЕ ШАТ

1961 оны VII сард ардын хувьсгалын 40 жилийн ойн өмнөхөн хуралдсан МАХН-ын XIV их хурлаас, Ардын засаг байгуулагдсаны 40 жилийн ойд зориулж ард түмэн, улс орны олсон ололт амжилтыг нэгтгэн дүгнэн цаашид УАА соёлыг тав таван жилийн төлөвлөгөөтэйгээр хөгжүүлэх тухай шийдвэрийг баталжээ.

Эмийн сангуудын тоо 43,8% үүнээс хөдөөгийн эмийн сан 52,8%-иар нэмэгдэж шинээр 64 эмийн сан байгуулагдсан байна.



Нэг эмийн санд ногдох хүн амын тоо 18,2%-иар буурч, нийт эм барааны ерөнхий эргэлт 59,1% үүний дотор хөдөөгийн эмийн сангуудын эм барааны эргэлт 49,9% тус тус өсөж байжээ.

1965 оны эцэст манай улсын бүх эмийн сангуудын 77,5%-ийг сумдын эмийн сангууд эзлэх болсон байна.

1970 онд нэг эмийн сангийн ачаалал 1965 оныхоос 14,8 хувиар буурчээ.

Тиймээс энэ таван жилд эмийн сангийн тоо 33,1%-иар, эмийн жижиглэн худалдаалах гүйлгээ 59,9%-иар тус тус өсчээ.

ДӨРӨВДҮГЭЭР ҮЕ ШАТ

1991 оноос Монгол улс анх удаа өөрийн үндэсний эмийн бодлоготой болох үүднээс ДЭМБ-тай хамтарч Үндэсний эмийн бодлогын 4 удаагийн бага хурал хийж “Эмийн талаар төрөөс баримтлах бодлого,”Эмийн тухай” хууль гаргах үндэс суурийг тавьснаар ДЭМБ-ын Үндэсний эмийн бодлоготой орны тоонд багтан орлоо.

2002 оны 10-р сарын 11-нд Эмийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай УИХ-ын 68-р тогтоол батлагдсан явдал нь, эм хангамжийн түүхэнд тохиолдсон нэн чухал үйл хэрэг боллоо.

2002 оны 4-р сарын 7-нд батлагдсан “Эмийн тухай” Монгол улсын хууль, 2002-ын 4-р сарын 19-нд өөрчлөн батлуулснаар Монгол улсад эм зүйн болон эм хангамжийн алба эрүүл саруулаар өсөж хөгжих эрх зүйн орчинтой боллоо.

Ийнхүү үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн заалтыг дөрөвдэх дэх удаагаа шинэчлэн мөрдөж байжээ.

Эмийн сан, эм хангамжийг задлаж хувийн секторыг төрийн бодлогоор дэмжснээр өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд хувийн эмийн сан 800 гаруй болж, хувийн эм ханган нийлүүлэх байгууллага 143, хувийн эмийн үйлдвэр 30 тус тус ажиллаж байна.



Эм хангамжийн салбарыг удирдан зохион байгуулах, зохицуулах үүрэг бүхий төрийн нэрийн өмнөөс ажиллах Эм зүйн албатай болсон явдал нь эм хангамжийн хөгжлийн IV үе шатанд олсон хөгжлийн том алхам болов.





ТАВДУГААР ҮЕ ШАТ

2007 оноос эхлэн үйл ажиллагаагаа олон улсын жишигт хүргэх, зах зээлд эзэлсэн байр сууриа бэхжүүлэх, тогтвортой өсөлтийн стратегийг ханган ажиллах болсон нь Монгол Эм Импэкс Концерны түүхэнд шинэ хуудсыг нээсэн юм. эн тэргүүнд компанийн үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэх, зах зээлд эзэлсэн байр сууриа бэхжүүлэх тогтвортой өсөлтийн стратегийг ханган ажиллах болсон юм.

Монгол Эм Импэкс Концерн үйл ажиллагаагаа илүү өргөжүүлэн Фарммаркет эмийн сангийн сүлжээгээрээ дамжуулан Улаанбаатар хотын болон 21 аймгийн хэрэглэгчиддээ ойртсон, тэдний хэрэгцээ шаардлагад суурилсан, орчин үеийн шинэлэг үйлчилгээгээ хүргэж, тохь тухтай орчинд өргөн сонголттой, чанарын баталгаатай бүтээгдэхүүнээр үйлчилж байгаа нь иргэдийн талархлыг хүлээж байна.

Монгол Эм Импэкс Концерн АНУ-ын People to people нийгэмлэгийн эрдэмтэн багш нарыг Монголд урьж ирүүлэн “Цусны төв”-тэй хамтарсан ээлжит сургалт, Өвөрхангай аймгийн бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эмч нарт зохион байгууллаа. Мөн Дэлхийн Хүүхдийн Мэс Засалчдын холбоо, ЭМЯ-тай хамтран мэс засалд нэн шаардлагатай мэдээгүйжүүлэгч эм тариа, бэлдмэлийг үнэ төлбөргүй, тусламжаар авч хот хөдөөгийн эмнэлэгүүдэд хурдан шуурхай хүргэв.

2010 онд Итали улсын хүүхдийн мэс засалчдын багийг Монголд урин авчирч ажиллахад нь бүх талын дэмжлэг үзүүлсэн бөгөөд, Монголд хүрэлцэн ирсэн багийнхан Өвөрхангай аймагт очиж 501 хүнд эрүүл мэндийн зөвлөгөө өгч, 30 гаруй хүнд мэс засал хийж, эмч нарт сургалт зохион байгуулсан юм.



“

**ЭМЧ МЭРГЭЖИЛТНЭЭС
ГАДНА ИРГЭДИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН
БОЛОВСРОЛЫГ
ДЭМЖИХ НЬ
ӨВЧЛӨЛИЙГ
БУУРУУЛАХАД
ЧУХАЛ НӨЛӨӨТЭЙ**

”

Монгол Эм Импэкс Концерн иргэдийн эрүүл мэндийн боловсрол, эмч мэргэжилтнүүдийн мэдлэгийг дэмжихэд чиглэсэн сургалт, симпозиумыг өөрийн санаачилсан Dr Study хөтөлбөрийг тогтмол зохион байгуулдаг. Өнгөрсөн 3 жилийн хугацаанд ард иргэд, эмч мэргэжилтнүүдэд зориулсан 300 гаруй удаагийн эрүүл мэндийн өдөрлөг, сургалт симпозиумыг зохион байгуулсан бөгөөд дэлхийн анагаах ухааны салбарт нэртэй эрдэмтэн, мэргэжилтнүүдийг Монголдоо урьж орчин үеийн эмчилгээний чиг хандлагын талаарх мэдээллийг эмч мэргэжилтнүүдэд хүргэн ажилласан байна. Мөн нийгмийн хариуцлагынхаа хүрээнд туслалцаа, дэмжлэг хэрэгтэй өвчтнүүдэд шаардлагатай эм бэлдмэлийг хандивлалаа. Тухайлбал, БНСУ-ын Green Cross компанитай хамтран ховор тохиолдох Джулиан Барре синдромтой өвчтөнд чухал шаардлагатай иммуноглобулин тариаг хандивлав. Мөн элэгний С вирусийн халдвартай 100 өвчтөнг эмчлэх MyDekla, MyHer бүтээгдэхүүнийг ХСҮТ-д гардуулсан юм.



Элэгний С вирусийн эсрэг ЛЕДВИР эмийн Монгол дахь албан ёсны нээлт



Сүүлийн жилүүдэд иргэдийн дундах нас баралтын голлох шалтгаан болоод буй элэгний өвчлөл тэр дундаа элэгний С вирусийн эмчилгээнд Монгол Эм Импэкс Концерн онцгой анхаарч АНУ-ын Mylan компанитай хамтран элэгний С вирусийн эсрэг өндөр үр дүн бүхий /99,7 хувийн үр дүнтэй/ ЛЕДВИР эмийг 2016 оны 4-р сарын 29-ны өдөр Монгол Улсад албан ёсоор нэвтрүүлсэн юм. Ингэснээр элэгний С вирусийн халдвартай өвчтөнд очих эмийн хүртээмж сайжирч, эмчилгээний зардал буурах таатай боломж бүрдсэн юм.



Монгол Эм Импэкс Концерн Монгол Улсын ЗҮС хэрэгжүүлж буй “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг идэвхтэй дэмжин ажиллаж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар ЛЕДВИР эмийн тусламжтайгаар 50,000 гаруй хүн аюулт өвчнөөсөө ангижраад байна. Мөн элэгний С вирусийн халдвар дамжих өндөр эрсдэлтэй нөхцөлд ажилладаг эмч мэргэжилтэн, тэдний гэр бүлийн гишүүдэд зориулсан “Халамж” хөтөлбөрийг санаачлан онцгой хөнгөлөлттэй нөхцлөөр ЛЕДВИР эмийг авах боломжийг бий болгосон юм.



Эх хүүхдийн эрүүл мэндийг сахин хамгаалах, тэр дундаа дутуу нярайн амьсгал хямралын шалтгаантай хүндрэл, нас баралтыг бууруулахад Монгол Эм Импэкс Концерн онцгойлон анхаарч эх барих, эмэгтэйчүүдийн эмч мэргэжилтнүүдэд зориулсан сургалтыг жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг. Сургалтад олон улсад энэ чиглэлээр нэртэй эрдэм, докторуудыг урьж оролцуулдаг бөгөөд Монголын эмч мэргэжилтнүүдэд орчин үеийн эмчилгээний чиг хандлагын талаар болон бодит туршлага олж авах том боломжийг нээж өгдөг юм.

Дутуу нярайн амьсгал хямралын эмчилгээ нь эмч, мэргэжилтнүүдээс өндөр хариуцлага, онцгой үр чадвар шаарддаг учир тэдний мэдлэг боловсролыг дэмжихэд чиглэсэн сургалт, арга хэмжээг зохион байгуулах нь нэн чухал ач холбогдолтой.

Монгол Эм Импэкс Концерн нь дутуу нярайн амьсгал хямралын хүндрэлийн үед зайлшгүй шаардлагатай Куросурф бэлдмэлийг Монголдоо оруулж ирэн эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудад тасралтгүй найдвартай хүргэж байна.

Энэхүү бэлдмэл нь дэлхийн 91 оронд хэрэглэгддэг бөгөөд амьсгал хямралын хүндрэлтэй 3,7 сая нярайг аварсан гайхалтай бүтээгдэхүүн юм.

Монгол Эм Импэкс Концерн олон жилийн туршлагатай, нийгэм, эрүүл мэндийн салбарт

тулгамдаад буй асуудлыг соргогоор мэдэрч түүнд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн, шаардлагатай эм бэлдмэлийг нарийн судалгааны үр дүнд оруулж ирдэг. Тухайлбал, чимээгүй тахал хэмээн нэрлэгддэг чихрийн шижин, түүнээс шалтгаалах хөлний шархны хүндрэлийг эмчлэх Heberprot-P бэлдмэлийг Куба улсын Биотехнологийн хүрээлэнтэй хамтран Монголд нэвтрүүлээд байна. Ингэснээр чихрийн шижин өвчний улмаас хөл тайрагдах эрсдэл буурах нөхцөл бүрдэж байгаа юм. Мөн АНУ-ын Mylan компанитай хамтран эмэгтэйчүүдийн хөхний хорт хавдрын эсрэг Хертраз бүтээгдэхүүнийг эмчилгээнд нэвтрүүлсэн юм.

Эм хангамжийн салбарын анхдагч Монгол Эм Импэкс Концерн өдгөө Улаанбаатар хот төдийгүй орон нутгийн 21 аймгийг бүхэлд нь хамарсан үйл ажиллагааны өргөн цар хүрээ бүхий салбар нэгжээрээ дамжуулан дэлхийн анагаахын шинжлэх ухааны инноваци, ололт амжилтыг шингээсэн эм, эмийн бүтээгдэхүүнийг хүн ардаа болон эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудад хурдан шуурхай найдвартай хүргэсээр байна. Бид цаашид үйл ажиллагаа, үйлчилгээгээ улам чанаржуулж, харилцагч байгууллага, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг цаг алдалгүй хүргэн ажиллах болно.

B.Well

Гэр бүлийн гишүүн бүрт

ДАРЛТТАЙ УСААР ШҮД ЦЭВЭРЛЭГЧ




Тав тухтай хэрэглээг хангасан гурван төрлийн үйлдэлтэй:
Энгийн - Амны хөндийн эрүүл ахуйд
Зөөлөн - Мэдрэмтгий шүдэнд
Цохилттой - Буйланд эмчилгээний массаж хийхэд



Орчин үеийн Ли-Ион батерейгаар тоноглогдсон бөгөөд нэг удаа цэнэглээд бүтэн нэг сарын хугацаанд хэрэглэх боломжтой

ДАВУУ ТАЛУУД

Гэр бүлийн болон хосуудын хэрэглээнд тохирсон өөр өнгийн 2 хошуутай
Цэнэглэх, ашиглахаас бусад үед 2 минутын дараа автоматаар унтарна
Адаптарийн тусламжтай хаана ч ашиглах, цэнэглэх боломжтой
Дуу багатай



Гурван үйлдэлтэй



Оновчтой хүч



Авсаархан

Дагалдах хэрэгсэл



Даралттай
усаар
шүд
цэвэрлэгч
аппарат



2 ширхэг
хошуу



150 мл-ийн
баг таамж
бүхий усны
сав



Адаптер



МОНГОЛ ЭМ ИМПЭКС КОНЦЕРНЫ

үе үеийн удирдлагууд



Эрдэнэ-Цогтын НАМСРАЙ /1898-1951/

1933-1937 оныг хүртэл Улсын эм бэлтгэлийн газрын анхны даргаар томилогдон ажиллаж байх хугацаандаа аж ахуйн ажлыг өрнүүлж шинээр эмийн сан байгуулах, зөвлөлтийн мэргэжилтэн нарыг урьж ажиллуулах, монгол ажилчдыг эмийн мэргэжилд бэлтгэн сургах ажлыг идэвхтэй гүйцэтгэж байсан бахархан дуурсах анхны дарга юм.

Сэрээтэрийн ЦЭРЭН /1900-1967/

1937 оноос Улсын эм бэлтгэлийн газрын даргаар ажиллаж эхэлсэн бөгөөд энэ хугацаандаа Монгол улсын сум бүрийг эмнэлгийн салбартай болгох үндэс суурийг анхлан санаачилсан гавъяатан бөгөөд, тухайн үеэс эмийн мэргэжилтнийг бэлтгэж байсан авьяаслаг удирдагч юм.

Дугаржавын БАТЦЭНГЭЛ /1913-1967/

1944 оноос Улсын эм бэлтгэлийн газрын даргаар ажиллаж эхэлсэн бөгөөд дайны дараах үеийн хохирлыг арилгах, эм эмнэлэгийн барааны хүртээмжийг дээшлүүлэх, эмийн сангийн тоог хот хөдөөд нэмэгдүүлэх, боловсон хүчин бэлтгэх зэрэг бодлогын чанартай ажлуудыг хийж байсан эмнэлгийн мэргэжилтэй анхны дарга байсан юм.



Цагааны ОЙДОВ /1907-1986/

1939 оноос Улсын эм бэлтгэлийн газрын даргаар ажиллаж эхэлсэн бөгөөд мэдлэг, хариуцлагаараа дайны жилүүдэд эм хангамжийг эрс нэмэгдүүлэх, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх зэрэгт өөрийн хувь нэмрийг оруулж байсан цуцашгүй удирдлагч юм.



Сономын РАВЖАА

1953 оноос Улсын эм бэлтгэлийн газрын даргаар багахан хугацаанд ажилласан ч соёлын довтолгооны энэ үед сумдад их эмчийн салбар байгуулагдах ажилд өөрийн хувь нэмрийг оруулсан юм.



Санжаагийн ПҮРЭВЖАВ /1928-1992/

1956 оноос Улсын эм бэлтгэлийн газрын даргаар ажиллаж байхдаа тус газрын эдийн засгийн байр суурийг бэхжүүлж, ЗХУ-н тусламжаар арьс өнгө, сүрьеэгийн багтай хамтран хүн бүрийг эрүүлжүүлэх ажлыг хийж байсан гавъяатан юм.



Даваагийн ЭРДЭНЭ-ОЧИР

1960 оноос Улсын эм бэлтгэлийн газрын даргаар ажиллаж байхдаа эмийн баазын барилга /Монгол эм импекс концерний байр/-г бариулахад хүчин зүтгэж эм хангамжийн түүхэнд өөрийн хувь нэмрийг оруулсан хүн юм.



Аюулгүйн ӨЛЗИЙХУТАГ

1958 оноос Улсын эм бэлтгэлийн газрын даргаар ажиллаж эхэлсэн бөгөөд энэ үеэс эмийн ургамлын судалгааны ангийг байгуулж, эм бэлтгэлийн газрын харьяа системийн байгууллагын хөгжлийн зүй тогтлыг гаргаж ирсэн анхны эмнэлэгийн дээд мэргэжилтэн, их эмч-эм судлаач дарга байсан юм.

С. ВАНДАГДОРЖ

1961 оноос Улсын эм бэлтгэлийн газрын даргаар ажиллах хугацаандаа эм хангамжийн системийн ажлыг зохион байгуулж, мэргэжилтэн бэлтгэх ажилд идэвхийлэн оролцож, эмийн тээврийн бааз байгуулах эхлэлийг тавьж байсан юм.



Мөнхзаяагийн БАНЗРАГЧ

1964 оноос Улсын эм бэлтгэлийн газрын даргаар ажиллах хугацаандаа гадаад худалдаа, эмийн үйлдвэрлэл, чанарын улсын хяналт, эмийн сан, салбар цэг, санхүү эдийн засаг гэх мэт олон салбар системийг удирдаж байсан удирдах арга барилыг олон талаар эзэмшсэн үлгэр жишээч даргын нэг байсан юм.



Дарьсүрэнгийн НЯМ-ОСОР

1965 оноос Улсын эм хангамж үйлдвэрлэлийн газрын даргаар ажиллах хугацаандаа гадаад улс орнуудаас импортоор эм, эмнэлгийн хэрэгсэл оруулж ирэх ажлыг идэвхийлэн гүйцэтгэж байсан эм хангамжийн салбарын үнэтэй хувь нэмэр оруулсан түүхэн домог болсон шилдэг удирдлагын нэг байсан билээ.



Гунаагийн СОДНОМДАРЖАА

1967 оноос эхлэн Улсын эм хангамж үйлдвэрлэлийн газрын даргаар 20 гаруй жил ажилласан бөгөөд энэ хугацаандаа гадаад улс оронтой хамтран эмийн ургамлын завод, цех байгуулах, экспортлох ажлыг эхлүүлсэн ба, эмийн боловсон хүчин бэлтгэх цэгцтэй бодлогыг хэрэгжүүлсэн эм хангамжийн амьд түүх болсон удирлагын нэг юм.



Авирмэдийн ЛАМЖАВ

1990 оноос эхлэн Улсын эм хангамж үйлдвэрлэлийн газрын даргаар ажилласан ба энэ хугацаандаа зах зээлийн шилжилтийн хүнд хэцүү үед гадаад худалдаандаа эмнэлгийн үйлчилгээнд дэвшил гаргаж чадсанаар, дэлхийн 50 гаруй улс оронтой эмийн худалдаа хийж улсын эм хангамжийг бүрдүүлж чадсан гавъяатан юм.



Рагчаагийн БЯМБАА

1993-2005 онуудад Улсын эм хангамж үйлдвэрлэлийн газрыг удирдаж байх хугацаандаа, дэлхийн улс орны эдийн засаг хямарч, гадаадаас авах эм, эмнэлгийн хэрэгсэлийн тоо эрс багасч хомсдол үүсч байх хүнд хэцүү он жилүүдэд тухайн үедээ тохирсон эм хангамжийн бүтцийг бий болгожээ. Р.Бямба гуайн үр дүнтэй ажиллагааны нэг нь, ДЭМБ, НҮБ-ын Хүн амын Хүүхдийн байгууллагатай нягт хамтран ажиллах үүд хаалгыг нээсэн шилдэг удирдлагын нэг билээ.



Готовын ЧОЙЖАМЦ

2004 оноос тус байгууллагын даргаар ажилласан бөгөөд энэ хугацаандаа “Монгол Эм Импекс Концерн” ХК-н 49%-г хувийн хэвшилд худалдах буюу үйл ажиллагааг нь шинэчлэх ажлыг шинэ сэтгэлгээгээр зохион байгуулж чадсан хүний нэг юм.



Батбаярын БОЛОРМАА

2007 оноос өнөөг хүртэл “Монгол Эм Импекс Концерн”-ий захирлаар ажиллаж байгаа бөгөөд хувьчлалын дараах зах зээлийн тогтворгүй, зогсонги үед олон улсын эмийн зах зээлд үйл ажиллагааны хүрээгээ тэлж, эдийн засгийн болон санхүүгийн чадавхыг сайжруулж, хөдөө орон нутгийн үйл ажиллагааг тасралтгүйгээр өсөн нэмэгдүүлж, компанийн зөв засаглалыг бий болгож үйл ажиллагааг шинэ шатанд гаргаж ирсэн. Энэ хугацаандаа шинжлэх ухааны ололт нотолгоонд тулгууралсан, өндөр хөгжилтэй орнуудад нэвтэрч буй шинэ бүтээгдэхүүн, эмчилгээний шинэ аргачлалыг ард иргэддээ өргөнөөр таниулан, эмнэлгийн практикт нэвтрүүлэн ажиллаж байна.

БИД ЭХ ОРНЫХОО ӨНЦӨГ БУЛАН БҮРТ АЖИЛЛАДАГ



Монгол Эм Импэкс Концерны хамт олны хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, хүн ардын төлөө хийж буй ажил бүхэн орон нутгийн 21 аймагт байрлах салбар нэгжүүдээр дамжин Монгол орны өнцөг булан бүрт хүрдэг юм.

Орон нутагт байгуулагдсан анхны салбар эмийн сан тэртээ 1928 онд Сэлэнгэ аймагт байгуулагдаж байсан бол хамгийн отгон салбар нь зууны бүтээн байгуулалт Эрдэнэт хоттой нас чацуу юм.

Хүн ардын эрүүл мэнд, амьдралын чанарыг дээшлүүлэх, эмийн бүтээгдэхүүний хүртээмжийг сайжруулах зорилгоор байгуулагдсан орон нутгийн салбар эмийн сан нь энэхүү түүхэн хугацаанд ард иргэдийн дунд “Төв эмийн сан” нэрээр хоногшсон байдаг.

ТӨВ ЭМИЙН САН

Төв эмийн сангууд нь аймаг орон нутгийнхаа эрүүл мэндийн салбарт төдийгүй, улс орныхоо хөгжилд үнэтэй хувь нэмэрээ оруулж ирсэн бөгөөд аймаг сумдын эрүүл мэндийн эрүүл мэндийн байгууллагуудыг болон хүн ардыг эм, эмэнэлэгийн хэрэгсэлээр хангах ажлыг 1990 оныг хүртэл дангаараа нэрт төртэйгээр гүйцэтгэж ирлээ.

Монгол Эм Импэкс Концерны 21 аймагт байрлах салбарууд нь салбартаа манлайлагч олон шилдэг боловсон хүчнийг бэлдэн гаргаж эмийн салбартаа

үнэтэй хувь нэмэр оруулсан бөгөөд тухайлбал Төрийн шагналт, академич Л.Хүрэлбаатар Хөвсгөл эм хангамжийн салбараас ажлын гараагаа эхэлж байсан түүхтэй.

Монгол Эм Импэкс Концерн цаашдаа Улаанбаатар хот төдийгүй орон нутгийн салбар эмийн сангийн үйлчилгээ, үйл ажиллагааг илүү өргөжүүлэн чанаржуулж алслагдсан аймаг сумдын эмч мэргэжилтнүүдийг чадавхжуулах, орон нутгийн бүс нутагт амьдарч буй ард иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дэмжихэд чиглэсэн ажлуудыг хийж хэрэгжүүлэх зорилтыг тавин ажиллаж байна.



Бид хүн ардын эрүүл мэндийн төлөө хийж бүтээсэн 95 жилийн туршлага, чадварлаг хамт олны хүчээр эм хангамжийн салбарын арвин түүхийг үргэлжлүүлэн бичиж байгаагаараа бахархдаг билээ.

ХҮН АРДЫНХАА ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨЛӨӨ АЖИЛЛАЖ БАЙГААДАА БАХАРХДАГ



Уншигчдынхаа өмнөөс танд энэ өдрийн мэнд хүргэе. Өөрийгөө танилцуулахгүй юу?

Сайн байна уу? Намайг Батнасангийн Шаравсамбуу гэдэг. Би Баянхонгор аймгийн Галуут суманд 1960 онд төрсөн. Баянхонгор аймгийн 10 жилийн сургуулийг сурч төгсөөд, Ардын армид 3 жил алба хааж ирээд 1985 оноос Монгол Эм Импэкс Концерндоо жолоочоор ажилд орж 34 дэх жилдээ тасралтгүй ажиллаж байна.

Та 34 жилийн хугацаанд хийж гүйцэтгэж буй ажил үүргийнхээ талаар танилцуулаач?

Би концерндоо ажиллах хугацаанд 21 аймгийн бүх сумдуудаар эм бараагаа тээвэрлэж хүргэх, НҮБ-ийн ХАС, ХС-тай хамтарсан төслийн тусламжийн эм барааг аймаг сумдуудаар хүргэх ажлуудыг хийж байсан. Эм, эмнэлгийн хэрэгслийг тээвэрлэхэд цаг хугацаатай уралдаж ажиллах болон тусгай нөхцөл шаардсан хариуцлагатай ажил гэдгийг цаг ямагт ухамсарлаж тээвэрлэлтийн үеийн найдвартай байдлыг хангаж ажиллаж ирсэн. Өвлийн хүйтэн болон, зуны халуун өдөр шөнө ямар ч үед эм бараагаа ачаад явдаг.

Багагүй хугацаанд жолооч мэргэжлээр ажилласан байна. Ажлын тань хамгийн сайхан зүйл нь таны хувьд юу вэ?

Машин тэрэг маань эвдрэл гэмтэлгүй, зам бартаа саадгүй дардан байж, эм бараагаа хүргэж өгөх

газартаа бүрэн бүтэн цаг хугацаанд нь хүргэж өгөх тэр үе л хамгийн сайхан байдаг даа. Хүн ардынхаа эрүүл мэндийн төлөө ажиллаж байгаагаараа үргэлж бахархаж явдаг.

Ахмад ажилтны хувьд Монгол Эм Импэкс Концернд ажиллаж байгаа шинэ, залуу ажилтнууддаа ямар зөвлөгөө, сургамж хэлэх вэ?

Дааж авсан ажилдаа хариуцлагатай, санаачлагатай байж, ахмадуудаа хүндэлж, тэднийхээ туршлагаас суралцаж, үр бүтээлтэй сайн ажиллаж хөдөлмөрлөх нь аз жаргалтай амьдралын үндэс суурь байдаг шүү гэдгийг хэлмээр байна.



Танд баярлалаа.

“

БИД 50 МЯНГА ГАРУЙ ӨВЧТӨНД ЭЛЭГ БҮТЭН АМЬДРАЛ БЭЛЭГЛЭСЭН

”



Сайн байна уу? Уншигчдынхаа өмнөөс танд энэ өдрийн мэндийг хүргэе! Монгол Эм Импэкс Концерн “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хүрээнд элэгний С вирусийн дэвшилтэт эмчилгээг Монголд нэвтрүүлээд багагүй хугацааг өнгөрүүлээ. Энэ эмчилгээний талаарх мэдээллийг уншигчдад өгөхгүй юу?

Баярлалаа. Уншигчиддаа энэ өдрийн мэнд хүргэе. Анх 2016 оны 4 сард анх АНУ-ын Mylan компанитай хамтран элэгний С вирусийн эмчилгээний “Лэдвир” эмийг Монгол улсын бүртгэлд албан ёсоор бүртгүүлэн, ард иргэдэд хүргэсэн. Үүнээс хойш хэдийн хоёр жил гаруй хугацаа өнгөрсөн байна. Хэдийгээр 2016 оны 4 сард Ледвир эм орж ирсэн боловч энэ ажлын эхлэл 2013 оноос буюу дэлхий нийтээрээ Элэгний С вирусийг эмчлэх тэр бэлдмэлийг гаргаж авсан цаг үеэс эхтэй юм. 2013 оноос өмнө элэгний С вирүстэй өвчтөнүүдийн нэг хэсэг нь элгээ солиулах мэс засалд ордог байсан бол нөгөө хэсэг нь эмчилгээний зардалгүйгээсээ болоод нас бардаг байлаа. Манай улсын хувьд элэгний вирусийн өвчлөл, нас баралт нь дэлхийн дундажтай харьцуулахад 10 дахин их байсан бөгөөд энэ эмчилгээ нэн шаардлагатай орны нэг байсан. Удалгүй 2014 онд элэгний С вирусийн эмчилгээний “Sofosbuvir 400mg+Ledipasvir 90mg” бэлдмэлийг үйлдвэрлэдэг компани нь тухайн эмийг үйлдвэрлэх бүх эрх, техникийн Ноу Хау-гаа 10 гаруй компанид албан ёсоор шилжүүлэн өгсөн. Уг эрхийн дагуу хөгжиж буй болон буурай 91 орны иргэд элэгний С вирусийн эмийг хамгийн боломжийн өртгөөр худалдан авах болжтой болсон бөгөөд тухайн 91 орны нэг нь Монгол улс байсан.

Энэ үеэс бид элэгний С вирусийн эсрэг эм үйлдвэрлэх эрх авсан компаниудтай 2014 оноос холбогдож эхлэсэн бөгөөд үүний үр дүнд 2015 онд женерик эм үйлдвэрлэлээ дэлхийд 2-т ордог АНУ-ын Mylan компанитай холбоо тогтоон албан ёсоор хамтран ажиллаж эхлэсэн.

Дэлхийн хэмжээний уг компаниатай хамтран ажилласан энэхүү хоёр жил гаруйн хугацаанд бид бүхэн аль хэдийн 50 гаруй мянган иргэдэд хүрч, “Элэг Бүтэн” амьдралыг бэлэглэсэн гэдгээ дурдахад таатай байна.



Эмч, эмнэлгийн ажилтнуудад зориулсан “Халамж” төслийг санаачлан маш амжилттай хэрэгжүүлсэн байна. Энэ төслийн ажлыг эхлүүлэх болсон зорилго нь юу байсан бэ?

2016 оны байдлаар эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа 2000 гаруй ажилчид элэгний С вирусийн халдвартай байна гэсэн мэдээлэл байсан бөгөөд тухайн үед ЭМЯ-наас манай компани болон Mylan компанид хүсэлт гарган эдгээр ажилчидад элэгний С вирусийн эмчилгээг илүү хөнгөлөлттэй нөхцлөөр олгохыг хүссэн. Уг хүсэлтийг хүлээн авч эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа иргэд болон тэдний ард иргэдэд хандсан “ХАЛАМЖ ТӨСӨЛТ”-ийг мөн оны 9 сараас эхлэн хэрэгжүүлж эхлэсэн. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд 1500 гаруй иргэд элэгний С вирусийн эмчилгээг хөнгөлөлттэй нөхцөлөөр авсан байна.

“Элэг бүтэн Монгол” хөтөлбөрт Монгол Эм Импэкс Концерны оруулсан хувь нэмрийг ерөнхийд нь дүгнэвэл...

Засгийн газрын хэрэгжүүлж буй “ЭЛЭГ БҮТЭН МОНГОЛ” хөтөлбөрийг миний хувьд эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлж байгаа хамгийн амжилттай, томоохон төслийн нэг гэж хардаг. Учир нь уг төслийн хүрээнд Засгийн газар, Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, мэргэжлийн холбоод, лабораториуд, эмч нар, төрийн бус байгууллага болон эм ханган нийлүүлэх байгууллагууд гээд хамааралтай байгууллага, нэгжүүд нэгдсэн нэг зохион байгуулалтанд орж, бие биенээ дэмжин хамтран ажиллаж байна.

Монгол Эм Импэкс Концерны энэ хөтөлбөрт оруулсан хувь нэмрийн тухайд 50 гаруй мянган иргэдэд хүрч ажиллахад мэдээж амар байгаагүй. Хамгийн гол нь бид нийгмийн хариуцлагынхаа хүрээнд бүтээгдэхүүнийхээ үнийг үе шаттайгаар тогтмол бууруулж, иргэдэд вирусийн эмчилгээний эмийн хүртээмжийг сайжруулсаар ирсэн явдал юм.



Цаашдаа элэгний өвчлөлийг бууруулах, 2020 онд элэгний С вирусгүй анхны улс болох үндсэн зорилгын хүрээнд ямар ажлуудыг хийж хэрэгжүүлэх вэ?

Засгийн газрын хэрэгжүүлж буй “Элэг Бүтэн Монгол” хөтөлбөрийн үндсэн зорилго бол 2020 он гэхэд бид бүхэн элэгний С вирусийг эмчлэх, энэ асуудлаа шийдсэн анхны улс болох явдал юм. Уг хөтөлбөрийн хүрээнд дээр дурьдсан байгууллагууд, нэгжүүд нь иргэдийг элэгний С вирусийн оношилгоо, эмчилгээнд эрт хамрагдах, хүндрэл гаргахгүй байх бүх бололцоог ханган ажиллаж байна.

Эрүүл мэндийн даатгалаа төлдөг иргэд маань даатгалаараа дамжуулан элэгний с вирусийн оношилгоо, эмчилгээндээ үнэгүй хамрагдах боломжтой. Одоогийн байдлаар улсын хэмжээнд элэгний С вирусийн эмчилгээнд хамрагдсан байдал ойролцоогоор дөнгөж 50 хувьтай байгаа. Оношилгоондоо хамрагдаагүй иргэд вирусийн халдвар нь хүндрэхээс сэргийлж оношилгоо, эмчилгээндээ эрт хамрагдах хэрэгтэй. Эрүүл байна гэдэг зөвхөн тухайн хүний өөрийн асуудал биш бөгөөд өөртөө болон хайртай дотны хүмүүсийнхээ өмнө хүлээсэн маш том хариуцлага шүү дээ. Иймд иргэд маань оношилгоо эмчилгээндээ идэвхтэй хамрагдахыг уриалж байна.



Ярилцлагынхаа төгсгөлд ажлын хамт олондоо баярласан талархсанаа илэрхийлмээр байна. Энэ жил манай байгууллагын хувьд онцгой жил юм. Хүн ардынхаа эрүүл мэндийн төлөөх амаргүй үйлсэд зүтгээд 95 жилийг ардаа орхисон байна. Монгол Эм Импэкс Концерн хэмээх энэ том айлын нэг гишүүн болж Монгол улсын өнцөг булан бүрт ажиллаж байгаа нийт ажилтнууд, мөн үе үеийн нийт ахмад ажилтнууддаа түүхт 95 жилийн ойн мэндийг дэвшүүлж байна. “Эрүүл Аз Жаргалтай Амьдрал”-ыг цогцлоохын төлөө бүхнээ зориулан өдөр шөнө ялгалгүй ажиллах Та бүхнийхээ урам зориг, тэвчээр, зүрх сэтгэлийг бахдаад ханашгүй. Хамт олондаа сайн сайхан бүхнийг хүсэн ерөөж аз жаргал хүсье.

Танд баярлалаа.



хүний эрүүл мэндийг хариуцан ажиллаж байгаа хүний мэргэжлийн үүрэг хариуцлага гээд их зүйлийг сурч мэдсэн. Өнөөдрийг хүртэл миний олж авсан мэдлэг туршлага, сайн сайхан бүхэн Монгол Эм Импэкс Концернтай салшгүй холбоотой.

34 жил гэдэг хүний амьдралд багагүй хугацаа. Мэдээж мэргэжилдээ юу юунаас илүү хайртай, дурлаж ажлаа хийдэг байх. Таны мэргэжлийн хамгийн сайхан нь юу вэ?

Юун түрүүнд хүний эрүүл мэндийн төлөө ажиллаж, хөдөлмөрлөж яваадаа маш их бахархдаг. Миний ажил эмийн тусламж үйлчилгээг маш чанартай, тэгш хүртээмжтэй, шударга үзүүлэхийг шаарддаг. Ингэхийн тулд үйлчлүүлэгчидтэйгээ мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг баримталж, хамгийн гол нь сэтгэлээсээ ажиллахыг хичээдэг. Эмийн санд орж ирж байгаа хүнд мэдээж ямар нэг өвчин, зовлон тохиолдсон байдаг учраас тэднийг ойлгож, мэргэжлийн хүний дэлгэрэнгүй, маш ойлгомжтой зөвлөгөө, мэдээллийг сэтгэлээсээ өгөх хэрэгтэй.

СЭТГЭЛД УХААРАЛ, ЗҮРХЭНД ХАЙР БАЙСАН ЦАГТ ҮЙЛДЭЛ БҮХЭН ЗӨВ БАЙНА

Сайн байна уу? Манай сэтгүүлийн уншигчдад өөрийгөө танилцуулахгүй юу?

Уншигчиддаа энэ ярилцлагыг унших мөчийн мэндийг хүргэе. Намайг Балдан овогтой Баяннэмэх гэдэг. Монгол Эм Импэкс Концерны төв салбарын эрхлэгчээр ажилладаг.

Монгол Эм Импэкс Концерн хэмээх энэ том айлын босгыг анх хэзээ алхан орж байсан бэ?

Би сургуулиа онц дүнтэй төгсөөд Хэнтий аймагт хувиарлагдсан л даа. 1986 онд анх аав минь намайг хөтлөөд Монгол Эм Импэкс Концерны үүдийг татаж байсан цагаасаа эхлээд өнөөдрийг хүртэл нийтдээ 34 жил Монгол Эм Импэкс Концерн гэдэг энэ байгууллагад ажиллаж байна.

Энэ хугацаанд ажлаасаа болон ажлын хамт олноосоо үйлчилгээний ажилтан ямар байх ёстой,



Хамтран ажиллаж байгаа шинэ, залуу ажилтнууддаа ямар зөвлөгөө сургамж хэлэх вэ?

Хийж байгаа зүйлдэ бүрэн сэтгэл зүрхээ зориулж, сэтгэлээсээ ажиллах нь аз жаргалтай байхын нэг нууц гэж би боддог. Ямар ч хэцүү ажил, хүнд бэрх давааг хийж чадна, бүтээнэ, болно гэсэн өөдрөг үзэлтэй байх нь ажлаа бүтээх хамгийн хялбар болоод хамгийн үр дүнтэй арга юм. Тийм учраас үргэлж өөдрөг, эерэг хандлагатайгаар ажлаа хийж байгаарай гэж зөвлөмөөр байна даа. Сэтгэлд хайр, зүрхэнд ухаарал байсан цагт үйлдэл бүхэн зөв байдаг юм шүү.

Танд баярлалаа.

АМЖИЛТТАЙ АЖИЛЛАХАД ХАМТ ОЛОН ҮНЭХЭЭР ЧУХАЛ ЮМ БАЙНА

Монгол Эм Импэкс Концерн 95 жилийн түүхтэй, ахмад байгууллага хэдий ч хүн ардынхаа эрүүл мэндийн төлөө энд уйгагүй ажиллаж буй хамт олны багагүй хэсгийг залуучууд эзэлдэг. Тэдний төлөөлөл болсон С.Чинбаяртай цөөн хором ярилцлаа. Тэр Монгол Эм Импэкс Концерноос ажлын гараагаа эхэлж одоо байгууллагын маркетингийн менежерийн албыг хашиж байна.

Сайн байна уу? Юуны өмнө уншигчдад өөрийгөө танилцуулахгүй юу?

Сайн байна уу? Намайг Сэр-Одын Чинбаяр гэдэг. Эм зүйч мэргэжилтэй. 2014 онд Улаанбаатар хотын Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их сургуулийг Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их сургууль нэртэй байхад нь Эм зүйч мэргэжлээр төгссөн. Одоо Монголын эм хангамжийн ууган байгууллага Монгол Эм Импэкс Концерны Маркетингийн албанд дөрөв дэх жилдээ ажиллаж байна.

Яагаад эм зүйч гэдэг мэргэжлийг сонгох болсон бэ? Эзэмшсэн мэргэжлийн тань хамгийн сайхан нь юу вэ?



Эм зүйч мэргэжлийг сонгосон шалтгаан маань сонирхолтой л доо. Анх би их эмч мэргэжлээр сурахаар төлөвлөчихсөн байсан ч олон талаар өөрийгөө хөгжүүлэхэд эм зүйч мэргэжил илүү тохирно гэж бодоод энэ мэргэжлийг сонгон суралцсан. Миний хувьд эзэмшсэн мэргэжлийн маань хамгийн сайхан зүйл нь хүмүүсийн эрүүл мэндийн төлөө ажилладаг нь бахархалтай санагддаг. Мөн олон талаар өөрийгөө хөгжүүлэх, хөрвөх боломжтой мэргэжил гэж боддог. Эм зүйч мэргэжлээр төгссөн хүмүүс эмийн сан, эм хангамжийн салбараас эхлээд багш, судалгаа шинжилгээ, лаборатор, менежер, цаашлаад оффисын ажилтанаар ч ажиллаж энэ чиглэлүүдээр өөрийгөө хөгжүүлэх, сурч мэдэх бүрэн боломжтой юм. Би өөрөө гэхэд л эм зүйч мэргэжлийнхээ дагуу маркетингийн чиглэлээр ажиллаж байна. Хөрвөх боломж сайтай болохоор энэ талын ихэнх мэргэжил рүү орж ажиллаж болно.

Түүнийгээ дагаад сурч боловсрох, мэдлэг чадвараа дээшлүүлэх зэрэг маш олон давуу талтай. Товчхондоо хэзээ ч уйдахааргүй мэргэжил. Төгссөөд сурч мэдсэн мэргэжилдээ дуртай байна гэдэг хувь хүн талаасаа маш том давуу тал л даа.

Хэзээнээс Монгол Эм Импэкс Концерн хэмээх байгууллагатай холбогдож ажиллах болсон бэ?

2013 оны 10 сард Монгол Эм Импэкс Концерн нийгмийн хариуцлагынхаа хүрээнд сурлага, идэвхи чармайлтаараа тэргүүлж буй оюутнуудад зориулсан тэтгэлэгт хөтөлбөрийг зарласан юм. Оюутан тус бүр 1000 ам.доллар бүхий тэтгэлэгийг 20 гаруй оюутанд олгож байсан. Энэ талаар багш нар маань надад хэлж санал болгосон юм. Өндөр шалгууртай, тэтгэлэгийн хэмжээ багагүй байсан учраас дотроо тэнцэж чадна гэдэгтээ итгэлтэй байгаагүй ч зориг гаргаж оролцоод Монгол Эм Импэкс Концерноос зарласан тэтгэлэгт

хамрагдсан 20 гаруй оюутнуудын нэг нь болж чадсан. Тухайн үед энэхүү тэтгэлэг миний хувьд маш их урам зориг өгч, цааш амжилттай сурч, ажиллах эрч хүч хайрласан үйл явдал болсон юм. Тэтгэлэгт хамрагдсан бусад оюутнуудад ч мөн адил тийм байсан гэдэгт итгэлтэй байна. Энэ үйл явдлаас хэдхэн сарын дараа бас нэгэн сайхан зүйл болсон нь Монгол Эм Импэкс Концерн надад ажлын санал тавьсан юм. Тухайн үед төгсөх курс байсан учраас энэ нь надад үнэхээр цагаа олсон зүйл болсон л доо. Мэдээж Монголын эм хангамжийн салбарын ууган байгууллага Монгол Эм Импэкс Концернд орж ажиллана гэдэг миний хувьд нэр төрийн хэрэг байсан учраас эргэлзэлгүй саналыг хүлээн авч шинэ ажилтнаар орсон. Өөрөөр хэлбэл миний ажил амьдралын гараа Монгол Эм Импэкс Концерн хэмээх энэ байгууллагатай салшгүй холбоотой юм.

Багагүй хугацаанд Монгол Эм Импэкс Концернд ажилласан байна. Энэ хугацаанд хувь хүн болоод мэргэжлийн хувьд юуг сурч мэдэж, хөгжсөн гэж боддог вэ?

Тэглээ. Багагүй хугацаанд энэ байгууллагад ажиллаж байна. Энэ бүх хугацаанд алдаа, амжилт хоёрын аль алиныг нь хослуулсан. Алдаа гаргахад хамт олон минь зааж зөвлөж, амжилт гаргахад хамт олон минь л урамшуулдаг. Амжилттай ажиллахад баг хамт олон үнэхээр чухал юм байна гэдгийг ойлгож мэдэрч байна. Онолыг сургуульдаа сураад ажлын талбар дээр гараад сурсан зүйлээ суурь болгож ашиглана гэдэг миний бодлоор тийм ч амар зүйл биш юм шиг санагддаг.



Дан ганц мэдлэг биш, хувь хүний хөгжлийг дээшлүүлэх олон талын чадварыг эзэмшиж байна. Дурдвал маш олон зүйл байна л даа. Ямартай ч залуусдаа хандаж нар өөд хараад зогсдог хүн биш нар өөд тэмүүлдэг хүн байгаарай гэж хэлмээр байна.

Монгол Эм Импэкс Концернд ажиллаж байх хугацаанд энэ байгууллагын үүсгэн байгуулагдсаны түүхт 95 жилийн ой тохиож байна. Сэтгэгдэлээсээ манай уншигчидтай хуваалцаач?

Анх 1923 онд тулгын чулуугаа тавьж өдийг хүртэл 95 жилийн турш Монгол улсын Эрүүл мэндийн салбарт томоохон хувь нэмэр оруулж яваа энэ том байгууллагын нэг эд эс болоод ажиллаж байгаадаа бахархаж энэ том айлын түүхийг бичилцэж яваадаа баяртай байдаг. Сэтгэгдэл маш өндөр байна. Ойн арга хэмжээний хүрээнд хийгдэх ажлууд маш их, зав багатай байгаа ч хамт олонтойгоо нэгэн зорилгын төлөө ажиллаж байгаадаа урамтай байна.



БИ ЗӨВЛӨӨ!

Пиковит®

Пиковитыг
хүүхэд бүрт

ШИНЭ
Пиковит®
ЮНИК
11 амин дэм
8 эрдэс бодис



+ КОНСЕРВАНТГҮЙ

+ САХАРГҮЙ

+ ХИЙМЭЛ АМТ ОРУУЛАГЧҮЙ

+ БУДАГЧ БОДИСГҮЙ



www.krka.mn

KRKA

Бидний мэдлэг, шинэчлэл нь
хамгийн чанартай, үр дүнтэй,
аюулгүй бүтээгдэхүүн
үйлдвэрлэхэд зориулагддаг.

ЧИХРИЙН ШИЖИНГИЙН ШАЛТГААНТ ХӨЛНИЙ ШАРХ



ТА ЭСВЭЛ ТАНЫ ГЭР БҮЛИЙН ГИШҮҮН ЧИХРИЙН ШИЖИНГИЙН ШАЛТГААНТ ХӨЛНИЙ ШАРХТАЙ БОЛ АНХААРАЛТАЙ УНШААРАЙ!!!

Чихрийн шижингийн хөлний шарх нь чихрийн шижингийн үед нийтлэг тохиолддог хүндрэл юм. Ихэвчлэн хөлийн эрхий хуруу болон өлмийн доор үүсдэг.

Чихрийн шижинтэй хүн бүрт хөлний өвдөлт болон шарх үүсэх эрсдэлтэй бөгөөд хөлөө сайн арчилсанаар урьдчилан сэргийлэх боломжтой. Хөлний шархны эмчилгээ нь үүссэн шалтгаанаасаа хамаарч ондоо байдаг тул таны хөлөнд ямар нэгэн өвдөлт, зовиур байгаа бол та эмчид хандана уу. Эс бөгөөс шарханд халдвар орсноор хөлөө тайруулахад ч хүрч болох юм.

ШИНЖ ТЭМДЭГ БА ОНОШЛОГОО

Хамгийн эхний шинж тэмдгүүдийн нэг нь таны хөлнөөс хэвийн бус шүүдэс гарч оймс болон гутлыг бохирдуулах байж болно. Хэвийн бус хавагналт, улайлт, тухгүй байдал, үнэр гарах зэрэг нь мөн эрт үеийн нийтлэг шинж тэмдэг болно.

Хүнд хэлбэрийн хөлний шархны хамгийн илэрхий шинж тэмдэг бол шархыг тойрон харласан эд үүсэх юм. Энэ нь шархыг тойрсон эдэд хангалттай цусан хангамж байхгүй байгаагаас үүснэ.

Шархыг тойрон хэсэгчилсэн эсвэл тархмал үхжил үүсэх нь шарханд халдвар үүссэнээс шалтгаална. Энэ тохиолдолд үнэртэй шүүрэл, өвдөлт болон мэдээ алдалт үүсэж болно.

Зарим тохиолдолд хөлний шарх нь танихад маш хэцүү бөгөөд халдвар авах хүртлээ ямар нэгэн шинж тэмдэг үзүүлэхгүй байж болдог. Хэрэв арьсны өнгө хувирах /ялангуяа харлах/ эсвэл эвэршсэн эмзэгшсэн хэсэгт өвдөлт мэдрэх юм бол та эмчдээ хандаарай. Эмч таны хөлний шархыг хүндрэлийнх нь байдлаас шалтгаалан дараах ангилалд үнэлнэ.

0: Шарх үүсээгүй боловч шарх үүсэх эрсдэлд орсон

1: Шарх үүссэн, халдваргүй

2: Гүнзгий шарх, үе болон шөрмөс өртсөн

3: Халдвар авсан том хэмжээний шарх, буглаа

ЧИХРИЙН ШИЖИНГИЙН ХӨЛНИЙ ӨВДӨЛТ БОЛОН ШАРХ ҮҮСГЭДЭГ ЗОНХИЛОХ ШАЛТГААНУУД

- Цусан хангамжийн дутал – цусан хангамжийн дутал нь судасны гэмтлээс шалтгаалан таны хөлөнд хангалттай цус очихгүй байна гэсэн үг бөгөөд энэ нь үүссэн шархны эдгэрэлтийг хүндрүүлдэг.

- Цусан дахь сахарын хэмжээ их байх – цусан дахь сахарын хэмжээ их байх нь халдварлагдсан хөлний шархны эдгэрэлтийг удаашруулдаг тул цусан дахь сахарын хэмжээг тогтворжуулах нь маш чухал.
- Мэдрэлийн гэмтэл – мэдрэлийн гэмтэл нь удаан хугацаанд үүсэх бөгөөд хөлний мэдээ алдах хүртэл үргэлжилж болно. Мэдрэлийн гэмтэл нь эхэндээ ирвэгнэх, өвдөх зэргээр илэрч болдог. Энэхүү мэдрэлийн гэмтэл нь хөлний өвдөлт мэдрэлтийг бууруулснаар та хөлөндөө мэдэлгүйгээр гэмтэл авч энэ нь шарх үүсэх эрсдэл үүсгэдэг.
- Эмзэгшсэн эсвэл гэмтсэн хөл – чихрийн шижинтэй өвчтөнүүдийн арьс хуурай байх нь элбэг байдаг. Хуурай арьс нь хагарах, эвэрших магадлал өндөр байдаг.

ХӨЛНИЙ ШАРХ ҮҮСЭХ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛҮҮД

Бүх чихрийн шижинтэй өвчтөн хөлний шарх үүсэх эрсдэлтэй байдаг ба зарим нэг хүчин зүйлүүд эрсдлийг улам нэмэгдүүлдэг.

- Чанар муутай эсвэл таараагүй гутал
- Ариун цэврийг муу сахих
- Хөлийн хумсыг буруу авах
- Архи, согтууруулах ундаа хэрэглэх
- Чихрийн шижингийн нүдний хүндрэл
- Зүрхний өвчлөл
- Бөөрний өвчлөл
- Таргалалт
- Тамхи таталт

Чихрийн шижингийн хөлний шарх нь настай эрэгтэйчүүдэд илүүтэй тохиолддог.

ЧИХРИЙН ШИЖИНГИЙН ШАЛТГААНТ ХӨЛНИЙ ШАРХЫГ ЭМЧЛЭХ НЬ

Хөл дээрээ гишгэхгүй байж шарх болон өвдөлтөөс сэргийлэхийг даралтгүйжүүлэх гэх бөгөөд энэ нь бүх төрлийн хөлний шархны үед үр дүнтэй. Алхалтаас үүсэх даралт нь халдварыг хүндрүүлж шархыг томруулдаг.

Хөлний хамгаалах хэрэгслүүдийг эмчийн зааврын дагуу зүүж хэрэглэх:

- Тусгай чихрийн шижингийн гутал
- Гипс
- Хөлний чиг
- Даралтат боолтууд
- Тусгай улавчууд

Хөлний шарх халдвар авахаас сэргийлэх аргууд:

- Хөлөө сайтар угаах
- Шархны боолтыг тогтмол сольж шархыг хуурай байлгах




- Шархны эргэн тойрны арьсыг ариутгах
- Бактерийн эсрэг үйлчилгээтэй тусгай боолт хэрэглэх

Эмийн эмчилгээ

Хөлний шарх халдвар авах нь маш ноцтой хүндрэл бөгөөд яаралтай эмчлэх шаардлагатай. Бүх халдварыг нэг аргаар эмчилдэггүй тул таны шархнаас дээж авч тусгайлан эмчлэх эмийг нь тодорхойлж болно. Хэрэв эмч тань таны шархны халдварыг ноцтой гэж үзвэл нэмэлтээр рентген зураг авхуулж халдвар ясанд хүрсэн эсэхийг шалгаж болно. Танай эмч антибиотик, цус шингэлэх, бүлэгнэлт бууруулах эмчилгээг үндсэн шархны эмчилгээнд нэмэлтээр хийж болно.

Мэс заслын эмчилгээ

Хэрэв өөр ямар ч эмчилгээ шархны эдгэрэлт болон хүндрэлээс урьдчилан сэргийлэхэд нэмэр болохгүй бол шархыг цааш хүндэрч тайралтанд хүрэхээс урьдчилан сэргийлэхийн тулд мэс заслын арга хэрэглэх шаардлагатай байж болно. Эмч таны хөлний шархны үхэжсэн эд, гадны биет болон халдварт өртсөн хэсгийг мэс заслын аргаар цэвэрлэж зайлуулах эмчилгээг хийж болно.



Шарх эдгээх биотехнологийн тариа эмчилгээ

Таны шархыг цэвэрлэн, халдвар болон үхэжсэн эд эсийг зайлуулсаны дараа Чихрийн шижингийн хөлний шархны эдгэрэлтийг түргэсгэх Хеберпрот П тариаг хийж болно. Энэхүү эмчилгээ нь биотехнологийн аргаар гаргаж авсан Куба улсын сүүлийн үеийн дэвшилтэт технологи бөгөөд дэлхийн 33 оронд хэрэглэж байна. Судалгааны үр дүнд энэхүү эмчилгээ нь хөлний шархыг эдгээж хөл тайруулах эрсдлийг 70%-р бууруулдаг болох нь тогтоогдсон. Тухайн тариа нь чихрийн шижингийн үед эд эсэд дутагдалтай байдаг хүний эпидермийн өсөлтийн факторыг шууд шарханд нөхөж өгснөөр архаг явцтай эдгэхгүй байгаа шархыг богино хугацаанд эдгээж цаашид үүсэх хүндрэл, хөл тайралтаас урьдчилан сэргийлдэг. Та тариа эмчилгээний явцад эмчийн зааврыг ягштал дагах нь эмчилгээний үр дүн хурдан гарах, үр дүн өндөр байх магадлалыг нэмэгдүүлдэг гэдгийг анхаараарай.

ЧИХРИЙН ШИЖИНГИЙН ХӨЛНИЙ ХҮНДРЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ

Чихрийн шижингийн хөлний шарх нь хөлний тайралтад хүргэх өндөр эрсдэлтэй тул шархнаас урьдчилан сэргийлэх нь маш чухал юм. Цусан дахь сахарын хэмжээгээ тогтмол хэвийн хэмжээнд барих нь чихрийн шижингийн хүндрэлүүдээс урьдчилан сэргийлэхэд хамгийн чухал үүрэгтэй. Мөн дараахь аргууд нь хөлний хүндрэлээс урьдчилан сэргийлэхэд тустай.

- Хөлөө өдөр бүр угаах
- Хөлний хумсаа зөв авах, хэт тулгаж авахгүй байх
- Хөлөө хуурай байлгаж, хөлний арьсаа хангалттай чийгшүүлэх
- Оймсоо тогтмол сольж байх
- Хөлний эмчид очиж эвэр, хатуурлуудыг авахуулж байх
- Хөлдөө таарсан гутал өмсөх
- Хөлний шарх нь эмчлүүлсний дараа ч эргэн дахих боломжтой тул шарх дахихаас урьдчилан сэргийлэхийн тулд тусгай зориулалтын чихрийн шижингийн гутал эсвэл улавч хэрэглэх нь зүйтэй.
- Хоолны дэглэмээ сайтар баримтлан цусан дахь сахарын

хэмжээгээ тогтмол байлгах. Тогтмол дасгал хийж, эмчийн бичсэн эмчилгээг зааврын дагуу хийхээ бүү мартаарай.

- Тамхи татаж болохгүй. Тамхи нь цусны урсгалыг саатуулж хөлний асуудлыг улам хүндрүүлнэ.
- Хөл нүцгэн явахгүй байх. Хөлдөө таарсан гутал өмсөж хөлөө холголтоос хамгаалах. Арьсан эсвэл даавуун зэрэг уян хатан, амьсгалдаг материалаар хийгдсэн гутал сонгож өмсөх.
- Өдөр бүр хөлөө шалгаж, цэврүү, урагдал, зүсэлт, хагарал, гэмтэл байгаа эсэхийг нягтлах. Хэрэв сайн харж чадахгүй байвал толь ашиглах эсвэл өөр хэн нэгнээр харуулах.
- Эмчийн үзлэгт орох болгондоо хөлөө шалгуулж хэвших. Хөлний асуудал үүссэн бол эмчид очиж занших. Эмчийн зааварчилгаа авалгүй өөрөө хөлний асуудлаа эмчлэх оролдлого хийхгүй байх.

ТАВИЛАН

Хэрэв эрт оношилвол хөлний шарх нь бүрэн эмчлэгддэг. Хэрэв ямар нэгэн хэмжээгээр шархлаа үүссэн бол яаралтай эмчид хандахгүй бол хугацаа алдах тусам халдвар орж хүндрэх магадлалтай. Эмчлэх боломжгүй халдварууд нь тайралт хийлгэх эрсдэлтэй байдаг. Эмчилгээ хийлгэж байгаа үедээ та хөл дээрээ явалгүй эмчилгээний төлөвлөгөөг сайтар дагаарай. Чихрийн шижингийн хөлний шархны эмчилгээ нь олон долоо хоногийн турш үргэлжилж болдог. Хэрэв таны цусан дахь сахарын хэмжээ өндөр, хөлөнд учрах даралт их байгаа тохиолдолд шарх хамаагүй удаан эдгэнэ. Хоолны дэглэмээ сайн баримталж, хөлөнд учрах даралтын бууруулах нь хөлний шархаа эдгэхэд үзүүлж буй хамгийн үр дүнтэй дэмжлэг юм. Шарх эдгэсний дараа урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авах нь шарх дахихаас сэргийлэх ач холбогдолтой.



Heberprot-P

Чихрийн шижингийн шалтгаант хөлний шархны эдгэрэлтийг хурдасгана

Шинж чанар болон давуу тал

Чихрийн шижингийн улмаас үссэн хөлний шархны грануляцийн процессыг идэвхжүүлж, арьсны хучуур эдийн нөхөн төлжих явцыг түргэсгэдэг. Шархны эдгэрэлтийн хугацааг богиносгоно.

Эдгээр давуу талууд нь эдийг болон мөчдийг мэс заслаар тайрагдах эрсдлийг бууруулахад нөлөөлдөг байна.

Хэрэглэх заалт

Зөвхөн эмчийн заавраар хэрэглэнэ.

Хеберпрот-П нь уламжлалт аргаар эдгэрэхгүй байгаа, мөчдийг тайрах өндөр эрсдэл бүхий Вагнерийн ангилалаар 3-4 шатанд байгаа 1см²-с дээш талбайг хамарсан ишемийн болон невропатийн гаралтай чихрийн шижингийн улмаас үссэн хөлний шархыг эдгээхэд зориулагдсан бэлдмэл юм. Эдийг мэс заслаар хэсэгчлэн цэгцлэх, ревазуларизаци хийх болон антибиотик эмчилгээ зэрэг бусад нийтлэг эмчилгээний аргуудтай энэхүү бэлдмэлийн эмчилгээг хавсарч хэрэглэж болно. Энэхүү бэлдмэл нь эдийн нөхөн төлжилтийн грануляцийн процессыг идэвхжүүлж, эдгэрэх явцыг түргэсгэдэг болохыг хэд хэдэн эмнэлзүйн триал судлагааны үр дүнгээр тогтоосон байсан.

Савалгаа

1 хайрцагт Хеберпрот-П® 75 мкг-г тус бүр агуулсан 6 туншилаар савлагдсан.

Хадгалах горим ба хадгалах хугацаа

2^o-8^oC хэмд 36 сар хүртэл хугацаанд хадгална.

НЕВЕРПРОТ-Р БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭМЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮН



CENTRO
DE INGENIERÍA GENÉTICA
Y BIOTECNOLOGÍA



Албан ёсны дистрибьютор
МОНГОЛ ЭМ ИМПЭКС КОНЦЕРН

Эрүүл мэндийн лавлах
1800-1923

Хүүхдийн шүд арчилгааны бааз



• Хүүхдийн
шүдний сойз

• Хүүхдийн шүдний
оо, сойзны сав


• Хүүхдийн
шүдний оо

Хүүхэд хаана



тэнг

Монгол Эм Импэкс Концерн
Эрүүл мэндийн лавлах 1800-1923



“

Элэгний өөхжилт өвчин буюу архины бус гаралтай элэгний өөхжилт өвчин нь элэгний эс (гепатоцит) –д өөх тос хуримтлагдаж, улмаар элэгний жингийн 5-10%-ийг эзлэхийг хэлнэ.

”

ЭЛЭГНИЙ ТАЛААР ХАРИЛЦАН ЯРИА

Архи хэтрүүлэн хэрэглэх нь элэгний өвчин үүсгэх цорын ганц шалтгаан биш юм. Бид энэ удаагийн дугаартаа элэгний өөхжилттэй өвчтнийг оролцуулсан бөгөөд эмч түүнийг үзээд элэг нь илүүдэл өөх тосны улмаас өвчилснийг тайлбарласан юм.

Хэдэн сарын өмнөөс баруун хавирганы доор хөндүүрлэж эхэлсэн юм. Цаг хугацаа өнгөрөх тусам баруун хажуугаар ямар нэг юм хатгаад байгаа мэт мэдрэмж төрөх болсон. Гэхдээ хурц өвдөлт ерөөсөө байгаагүй учраас эмчид хандахыг бодоогүй л дээ. Мөн зохисгүй хооллосон үед заримдаа дотор муухайрч, ам гашуу оргидог байсан тул ийм зовиур илрэхэд ч цочирдоогүй. Гэвч дотор муухайрч улмаар цэсөөр бөөлжихөд л би өөрийн бие организмыг өвдсөнийг анзаараагүй явснаа ойлгосон юм. Гастроэнтерологи эмчид үзүүлтэл ходоодный хурц үрэвсэл гэж оношлов. Элэг хавиар хөндүүрлэж байгаа тухайгаа хэлтэл элэгний эмчид үзүүлэхийг зөвлөсөн юм. Гэтэл элэгний эмч намайг яг өөрийнх нь өвчтөн байна гэж хэлэхэд нь маш их гайхав. Би чинь архи бараг хэрэглэдэггүй хүн, элгэнд ямар асуудал байхав дээ гэж бодож байв... Эмч миний биеийн жинд их анхаарал хандуулж, жинд гол асуудал байгаа тухай тайлбарлав. Харамсалтай нь их таргалсанаа хүлээн зөвшөөрөх цаг болсон байсан юм. 2 жилийн өмнө ажлаа сольсон ба шинэ ажил дээр цайны газар байсангүй. Ажлынхан маань гэрээсээ авчирсан хоолоо халааж эсвэл хоолны газарт иддэг байлаа.

Ажил ихтэй учраас гадагш гарч хоол идэж амжихгүй ажлын ширээндээ хооллодог байв. Өглөө ажилдаа ирэх замдаа пицца, пирожки, салат, шарсан тахиа, амттан худалдан авч, өдөр цайтай иддэг байлаа. Би анхнаасаа л туранхай байгаагүй бөгөөд 2 жилийн дотор 14 кг-аар нэмж таргалсан юм. Хэвлий, гуяараа илүү таргалав. Мөн элэгний эсэд өөх тос хуримтлагддаг юм байна. Би цусны биохимийн шинжилгээ өгч, хэвлийн ЭХО хийлгэсэн ба элэгний өөхжилт өвчин гэж оношлогдов.

ӨӨХ ТОС БА ДААВАР

Элэгний өөхжилт өвчин үүсэх хамгийн түгээмэл шалтгаан нь бодисын солилцооны алдагдал, дааврын өөрчлөлт болохыг эмч тайлбарлаж өгөв. Миний хувьд буруу хооллолт, таргалалт нь эхний шалтгаан байв. Би гэртээ зөв хооллохыг хичээж, 7 хоногт 1 удаа усан санд сэлдэг ч жин нэмэгдсээр байгаа бол энэ бүхэн нь хангалтгүй юм. Чихрийн шижингийн үед элэгний өөхжилт өвчин үүсэх тохиолдол их байдаг ба энэ надад тохиолдоогүй боловч, цусан дахь сахар болон холестерин хэмжээ бага зэрэг ихэссэн байсан. ЭХО-ийн шинжилгээгээр цөсний хүүдий агшилтгүй болсон

нь илэрсэн бөгөөд үүний улмаас цэс ихээр хуримтлагдсан ажээ. Элэгний өөхжилт өвчин 80-с илүү %-д амь насанд аюулгүй гэж эмч тайвшруулсан бөгөөд хэрэв архи хэтрүүлэн хэрэглэдэг бол өөхжилт фиброз болж улмаар элэгний хатуурал болдог байна. Элэгний өөхжилт өвчнийг эрт үед илрүүлэх нь хүндрэлтэй бөгөөд энэ үед өвчин бараг шинж тэмдэггүй явагддаг. Санаандгүй эсвэл доорх хоёрдогч шинж тэмдгүүд илэрсэн үед оношлогддог:

- Хэвлийн өөхний хэмжээ ихсэх
- Артерийн даралт ихсэх
- Цусан дахь инсулины хэмжээ ихсэх, глюкозын солилцоо алдагдах
- Арьсны жижиг судсууд өргөсөх, судасны тор эсвэл од үүсэх
- Эрэгтэй хүмүүст – хөхний булчирхай томрох

МЭРГЭЖИЛТНИЙ ТАЙЛБАР

Элэгний өвчнийг шинж тэмдгээр илрүүлж эсвэл сэжиглэж болохгүй, учир нь гэвэл элгэнд мэдрэлийн төгсгөл байхгүй бөгөөд элэг зүгээр үед өвдөнө гэж байхгүй. Элэгний хүнд өвчин, вирүсийн гаралтай гепатит, элэгний хатуурлын үед элэгний өвчний шинж тэмдгүүд болох шарлалт, элэг томрох шинжүүд илэрнэ. Илүүдэл жин, архи хэтрүүлэх хэрэглэх, В ба С вирүсийн гепатит, удамшлын хүчин зүйл, үрэвслийн эсрэг стероидын бус зарим бэлдмэл хэрэглэх зэрэг нь элэгний өөхжилт өвчинд хүргэнэ. Элэгний өөхжилт өвчний оношлогооны стандарт нь ЭХО бөгөөд түүний тусламжтайгаар элгэнд өөх хуримтлагдсаныг харж, фиброз байгаа эсэхийг тодорхойлж болно. Энэ бүхэн нь элэгний өөхжилт өвчин үүссэнийг илтгэнэ. Цусны шинжилгээгээр элэгний эс гэмтсэн эсэхийг тодорхойлно. Хэрэв элэгний эс гэмтсэн бол элэгний өөхжилт үрэвсэл үүссэнийг харуулах бөгөөд энэ үед илүү эрчтэй эмчилгээ шаардагдана. Мөн цусан дахь сахар, холестерин, инсулины хэмжээг тодорхойлж, инсулинд тэсвэртэй байдлын индексийг тооцно. Уг индекс нь өөхөн эд дааврын үйл ажиллагааг алдагдуулж байгаа эсэх, тусгай эмчилгээ шаардлагатай эсэхийг тодорхойлно. Юу идэж байна гэдэгтээ анхаарлаа хандуулна уу.

Хэрэв өөх тостой, шарсан, чихэрлэг хүнс давамгайлж байвал ашиг тустай бүтээгдэхүүнээр солих хэрэгтэй. Архи хэрэглэхгүй байх нь чухал бөгөөд архийг хэвийн хэмжээнээс бага зэрэг хэтрүүлэн хэрэглэхэд элэгний өөхжилт өвчин улам даамжирдаг. Эмчийн заалт, онцын шаардлагагүйгээр илүү эм бэлдмэл хэрэглэж болохгүй. Түүнээс гадна ургамлын найрлагатай тураах цайнууд элэгний үйл ажиллагаанд муугаар нөлөөлдөг.

“

ЭЛЭГНИЙ ӨӨХЖИЛТ ӨВЧНИЙ ҮЕ ШАТ

0 - Элэгний зарим эс өөхний жижиг хэсгийг агуулдаг.

I - Элэгний эс дэх өөхний хэсгүүд томорч өөхөн голомт үүсгэдэг (33% гэмтсэн эс).

II - Жижиг, дунд, том өөхөн хэсгүүд элэгний эсийн 33-66%-д агуулагдана.

III - Том өөхөн хэсэг эсийн хязгаараас давж уйланхай үүсгэнэ. (66%-с илүү хэмжээний гэмтсэн эс)

”

ХООЛЛОЛТ – ЭРҮҮЛ АМЬДРАХ ҮНДЭС

Эмч хамгийн эхэнд жин хасах, биеийн хөдөлгөөн хийхийг зөвлөсөн. Бага порцоор олон удаа, хоногийн илчлэгийн хэмжээг багасган хооллохыг зөвлөсөн. Уураг (тахиа, үхрийн мах, өндөг), үр тариа, цардуулгүй ногоо, жимс, ашигтай тос – оливын тос, сүүн бүтээгдэхүүн зэрэг нь хүнсийг бүрдүүлэх ёстой. Би гэртээ хоол бэлдэж, саванд хийн өдөрт 5-6 удаа 3 цагийн зайтай хооллохоор болов. Тослог ихтэй мах, бүх давсалсан, утсан бүтээгдэхүүн, халуун ногоотой хоол хүнс хэрэглэхийг хориглов. Гурилан бүтээгдэхүүний оронд лууван, сельдерей, алим идэж байв.

Цай уухаа багасгаснаар хаван буурав. Нойр булчирхайн үйл ажиллагаанд зориулан нэмэлтээр ферментүүд, цэсний хүүдийн гүрвэлзэх хөдөлгөөнийг сайжруулж, цэс ялгаралтыг дэмжих зорилгоор урсодиксихолийн хүчил өгөв.

7 хоногт 2 удаа усан сан явдаг болов. Өдөрт хамгийн багадаа 7000 алхам хийж байхын тулд утсандаа тусгай программ татаж авав. Биеийн жинг 8-10%-р бууруулахад элэгний үйл ажиллагаанд сайнаар нөлөөлдөг болохыг эмч нар батладаг.

МЭРГЭЖИЛТНИЙ ТАЙЛБАР

Биеийн жинг ядаж 10%-р буулгах хэрэгтэй, ингэхдээ аажмаар, 7 хоногт 1 кг-с илүүгүй, өөрөөр хэлбэл сард 4 кг хасах хэрэгтэй. Мөн биеийн хөдөлгөөнөөр жинг хасах ба агаарын дасгал байна уу зааланд байна уу ялгаагүйгээр спортод өдөрт 1-с багагүй цаг зарцуулах шаардлагатай. Хэрэв жин багасахгүй байвал хоолны дэглэмээ өөрчилж, дотоод шүүрлийн эмчид хандах нь зүйтэй ба инсулин ба сахарт асуудал байж болзошгүй юм.

Элэг цэвэрлэх нэмэлт бүтээгдэхүүн хэрэглэж болохгүй. Энэ нь элэгнээс өөхийг гадагшлуулж чадахгүй. Үрэвслийн үед үрэвсэл дарах, элэгний үйл ажиллагаа, бүтцийг сэргээх бэлдмэл хэрэглэх хэрэгтэй. Элэгний өвчжилт өвчнийг эмчлэхэд тодорхой хугацаа шаардагдах боловч эмчилгээний үр дүнд элэгнээс өөх бүрэн гадагшилж, үрэвсэл ба фиброзгүй болно.

Урсосан

Урсодеоксихолийн хүчил

PRO.MED.CS
Praha a. s.


Элэг хамгаалагч, цэсэн дэх холестерин члуу уусгагч бэлдмэл

Эрүүл мэндийн лавлах
1800-1923

- Элэгний эсийг хамгаална
- Цэсний чулууг уусгана
- Ам гашуун оргилтыг арилгана



ХОРТ ХАВДРЫН ЭМЧИЛГЭЭНИЙ ШИНЭ КОД



“
Сүүлийн арваад жилд хорт хавдрын эмчилгээнд олон шинэ зүйл бий болсон. Чанартай байшин сайн сууриас эхэлдгийн адил ямар ч онош зөв оношилгооноос эхэлдэг.
”

Позитрон-эмиссийн томограф

Энэ арга нь хавдар судлалд жинхэнэ хувьсгал хийсэн. Эмч нар цусны шинжилгээ болон хэд хэдэн төрлийн хорт хавдрын үед үүсэх шинж тэмдэг дээр тулгуурлан сэжиг төрвөл анхны хавдар хаана байгааг тааж оношлохгүйгээр олж илрүүлэх боломж нээгдсэн юм. Энэхүү арга нь эмчилгээний үр дүнг хянахад ч хэрэглэгддэг. Позитрон-эмиссийн томограф нь хавдар дахих болон бичил үсэрхийллийг өөр оношилгооны аргууд, тухайлбал мультиспираль компьютерийн томограф илрүүлэхээс өмнө илрүүлэх боломж олгоно. Позитрон-эмиссийн томограф нь анатомын биет биш харин хавдрын эсийн түргэн бодисын солилцоог олж тодорхойлдог. Үүний тулд шим тэжээлийн бодис тухайлбал, глюкозыг цацраг идэвхт изотопын тусламжтайгаар тэмдэглээд (цацрагт эмийн бодис хэмээх бодис үүснэ), дараа нь тухайн бодис хамгийн ихээр хуримтлагдаж буй газрыг тэмдэглэн авна. Позитрон-эмиссийн томограф болон компьютерийн томограф нь хавдрын байрлалыг яг таг тодорхойлдог.

МЭРГЭЖИЛТНИЙ ТАЙЛБАР

Позитрон-эмиссийн томограф болон компьютерийн томограф нь хортой лимфомыг оношлох, эмчилгээг хянах мөн уушги, улаан хоолой, ходоод, нойр булчирхайн хорт хавдрын үед мэс засал хийж болох эсэхийг тодорхойлоход зайлшгүй шаардлагатай зүйл болсон. Позитрон-эмиссийн томограф болон компьютерийн томографийг хорт хавдрын эсийн

тархалтын зэргийг тодорхойлох, хавдрын зөвхөн сэжиг байгаа үед хавдрын эсийг илрүүлэх зорилгоор хэрэглэгддэг. Энэ шинжилгээ өмнө нь зөвхөн онцгой шаардлагаар хийгддэг байсан бол, өнөөдөр түүний өндөр мэдээлэлтэй, үр дүнтэй болох нь хорт хавдартай бараг бүх өвчтөнд батлагдаад байна.

Гистологийн бэлдмэлийг үнэлэх ба иммуногистохимийн судалгаа

Харамсалтай нь, гистологийн худал онош өмнөхийн адил тулгамдсан асуудал хэвээр байна. Хавдрын эмч нар хавдрын өвчний патоморфологийн оношилгооны зөвхөн мэргэшсэн, том хавдрын төвүүдэд хийхийг зөвлөж байна. Хэрэв өөр газар оношлогдсон бол шил, блокийг авч дахин шалгуулах хэрэгтэй. Хавдар судлалын эмгэг судлаач оношинд эргэлзвэл иммуногистохимийн болон өөр бусад молекулын шинжилгээ хийнэ. Бүх шаардлагатай шинжилгээг хийсний дараа багагүй тохиолдолд хавдрын онош үгүйсгэгддэг.

МЭРГЭЖИЛТНИЙ ТАЙЛБАР

Бид эмнэлэгтээ хавдрын эдийн анхдагч дээжийг авдаг, учир нь гэвэл эмчилгээний аргыг тодорхойлоход суурь болох молекулын шаардлагатай шинжилгээ ихэвчлэн хийгдээгүй байдаг. Хавдрын эдийн шинэ дээж авч, хавдрын үе шатнаас хамааран эмчилгээ хийхийн тулд бид өвчтөнүүддээ компьютерийн томографийн хяналтан дор пункцийн биопси хийхийг зөвлөдөг. Эмчилгээний үед хавдар шинж чанараа байнга өөрчилж байдаг тул энэ маш чухал юм.

Хавдрын нэг үе шатанд тохирдоггүй байсан эмчилгээ дараа нь үр дүнтэй байж болох ч талтай. Бид тухайн өвчтөнд таарсан, молекулын мутаци дээр суурилсан эмчилгээг хийж буй үед онцгой чухал юм.

Эмчилгээ хор багатай, зөөлөн, илүү үр дүнтэй болж өөрчлөгдсөн.

Бай эмчилгээ

Хавдрын эсийн молекулын мутаци нь хавдрын эмчилгээний шинэ арга – бай эмчилгээ гаргаж авах үндэс болсон. Хорт хавдрын эсийг устгах зорилготой хими болон туяа эмчилгээнээс ялгаатай нь бай буюу биологийн эмчилгээ нь хавдрын эсийн өсөлтийг зогсооход чиглэдэг. Хавдрын өсөлтөнд чухал үүрэг гүйцэтгэдэг, мутацийн үед үүсдэг тусгай молекулд нөлөөлдөг. Эмчилгээний шинэ аргын чухал давуу тал нь хоргүй, туяаны нөлөөлөлгүй тул өвчтөнд зохицох нь хамаагүй сайн.



МЭРГЭЖИЛТНИЙ ТАЙЛБАР

15 жилийн өмнө нийтлэгдсэн хорт хавдрын геномын талаарх атласын ачаар ямар ген, түүний молекулын өөрчлөлтүүд хавдрын эсийн хөгжил, тархалтад нөлөөлдөг талаар бид мэднэ. Атлас хийгдсэний дараа бүдүүн гэдэс, хөх, уушги, бөөрний хорт хавдрын эмчилгээний бэлдмэлүүдийн үйлдвэрлэл эрчтэй эхэлсэн. Тийм бэлдмэлүүд хавдрын молекул руу чиглэн нөлөөлж хавдрын өсөлтөд саад болдог. Ийм бэлдмэлүүд хавдрын эсийг эрүүл эстэй хамт устгадаг уламжлалт хими эмчилгээг халж байгаа юм. Гэсэн хэдий ч ихэнх тохиолдолд хими эмчилгээг урьдын адил эмчилгээний үндсэн хэлбэр болгон хэрэглэсээр байгаа ба үр дүн нь практик дээр батлагдаад буй бай эмчилгээ, дархлаа эмчилгээг эмчилгээний нэмэлт арга болгон ашиглаж байна.


Дархлаа эмчилгээ

Бидний бие организмд гэмтэлтэй, хорт хавдрын байж болзошгүй эсүүд минут тутамд бий болж байдаг ба ийм эсүүдийг дархлааны тогтолцоо устгаж байдаг. Гэхдээ үүссэн эсийг дархлаа устгалгүй, уг эсэд хяналтгүй хуваагдах боломж олгох үед эс бэхжиж улмаар хавдар дархлааны эсийг саажилтад оруулах биологийн идэвхт бодис ялгаруулж эхэлдэг. Дархлаа эмчилгээний зорилго нь – хавдар руу довтлох бус, харин дархлааг хавдраас хамгаалж тайван ажиллуулах юм. Энэ зорилгоор моноклон эсрэг бие, цитокин, дархлааны бодис агуулсан бэлдмэлүүд зохион бүтээгдсэн. Өвчний 4-р үе шатанд байгаа өвчтөнүүд өмнө нь хэдэн сарын дотор нас бардаг байсан бол сүүлийн жилүүдэд бай эмчилгээний нэг төрөл болох дархлаа эмчилгээний тусламжтайгаар өвчнийг олон жил намжмал байдалд оруулж чадаж байна. Энэ шинэ эмчилгээний ачаар хавдрын талаарх хандлага ихээхэн өөрчлөгдсөн. 20 жилийн өмнө хавдрын 3-р үе шатанд байгаа өвчтөнүүдийг эдгэрэхгүй гэж үзэж байсан бол, өнөөдөр өвчний 4-р үе шатны үед өвчтөний амьдралын чанарыг алдагдуулалгүйгээр амьдралыг олон жилээр уртасгах, бүр өвчнийг бүрэн намжааж ч болно. Эмчилгээний шинэ хэлбэр нь хавдрыг мэс засал хийж болохгүй байдлаас мэс засал хийж болох болгож, мэс заслаар бүрэн авах боломж олгож байна. Үе үеийн хавдрын эмч нарын мөрөөдөл биелж 4-р шатны хавдар эмчлэгдэх боллоо.



МЭРГЭЖИЛТНИЙ ТАЙЛБАР

Дархлаа эмчилгээ олон хорт хавдрын эмчилгээнд шинэ хуудас нээсэн. <<Дархлаанд туслах>> хэмээх эмчилгээний үр дүн нь уушгины хорт хавдар, хорт меланом, бөөр, давсаг, ходоод, амны хөндий, төвөнхийн хорт хавдрын эмчилгээний үед үр дүнтэй болох нь практик дээр батлагдсан. Түүнээс гадна дархлаа эмчилгээ лимфомын зарим төрөл, бүдүүн гэдэс, нойр булчирхайн хавдрын үед хэрэглэгддэг.



ХАВДРЫН ЭСРЭГ ОРЧИН ҮЕИЙН БАЙ ЭМЧИЛГЭЭ

HERTRAZ

Trastuzumab for injection

- Хөхний хорт хавдрын эрт үе
- Хөхний үсэрхийлсэн хорт хавдар
- Ходоодны үсэрхийлсэн хавдрын эсрэг эмчилгээнд хэрэглэнэ.

Танг амьдрал бэлэглэнэ



Эрүүл мэндийн лавлах **1800-1923**

Албан ёсны дистрибьютор Монгол Эм Импэкс Концерн

ШҮДНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТАЛААР 5 АСУУЛТ



Хийжүүлсэн ус
шүдэнд ямар
нөлөөтэй вэ?

Маш муу. Нүүрс хүчлийн хий чихэртэй усанд уусаад шүдийг гэмтээж, пааланг уусгах хүчлийг үүсгэдэг. Үүнээс гадна чихэртэй хийжүүлсэн ундааг тогтмол хэрэглэснээр шүд-буйлны товруу үүсгэж чихэр нь хүчил болон хувирч шүд цоорол үүсэх таатай нөхцөл бүрддэг.



Гүзээлзгэнэ жимсээр
шүдээ цайруулж
болох үү?

Цэвэрлэх, цайруулах гэдэг ойлголтыг олон хүн андуурдаг. Үнэн хэрэгтээ хэрчим гүзээлзгэнээр шүдийг арчихад, гүзээлзгэнэд агуулагддаг бага хэмжээний жимсний хүчил шүдний өнгөрийг багасгах чадвартай тул инээмсэглэлийг илүү тод болгох магадлалтай. Гэхдээ шүдийг нэг тоноор ч гэсэн цайруулах боломжгүй. Гүзээлзгэнэ идэх нь шүдний эмчид очихоос хялбар тул энэ явган яриа одоог хүртэл явсаар байна.



Амрахаар явахдаа
шүдний гэнэтийн
өвчнөөс сэргийлэхийн
тулд юу дэлгэх
ёстой вэ?

Даралттай усаар шүд цэвэрлэгч, шүдний утас байнга авч явах нь тустай. Гэхдээ аялал, амралтаар явахын өмнө шүдний эмчид үзүүлж, шинжилгээ хийлгэж, зовиураа эмчид хэлэх нь зүйтэй. Учир нь гадаадад шүд хүчтэй өвдвөл эмчилгээ нь маш өндөр төлбөртэй байх нь элбэг. Түүнээс гадна эмнэлгийн тусламж хурдан, чанартай авахад хүндрэлтэй байж болох шүү дээ.



Жимс жимсгэнэ
шүдний пааланг
аюулгүй юу?

Жимс жимсгэнэ нь таны зуны улиралд хэрэглэх хүнсний ердийн л хэсэг юм. Энэ ямар нэг байдлаар шүдний пааланг бэхжүүлдэг эсэх нь батлагдаагүй зүйл боловч шүдэнд муу нөлөө үзүүлдэггүй учир та санаа зовохгүйгээр жимс жимсгэнэ хэрэглээрэй.



Шүдэнд ямар
хүнсний бүтээгдэхүүн
тустай вэ?

Аарц, исгэлэн сүүн бүтээгдэхүүн, бяслаг, чанартай мах, загас нь шүдний эрүүл мэндэд тустай. Гол нь хүнсний бүтээгдэхүүн шинэ, чанартай байх ёстой гэдгийг санаарай.

Шүдний эрүүл мэнд нь хүний гоо сайхнаас эхлээд биеийн бүхий л хэсэгт хамаатай учир шүд цоорох, өвдөх нь таны бие эрхтэнд муугаар нөлөөлж олон өвчний шалтгаан болдог байна. Иймээс амны хөндий, шүдний эрүүл мэндийг сайтар сахиж, тогтмол шүдний эмчид очиж байхыг зөвлөж байна.